

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Налайх дүүрэг дэх политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/152-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:2616663 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn Аудитор: Д.Батчимэг Утас: 261729 Цахим хаяг: Batchimegda@audit.gov.mn Пийк ОМ Аудит ХХК-ийн захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomauditllc@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.2 Албан шаардлага.....	22
5.3 Зөвлөмж	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/427
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Налайх дүүрэг дэх политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 383,713.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант онд дотуур байрны хүүхдийн хоолны 73,046.1 мянган төгрөгийн материалыг шууд худалдан авч, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан тооцож, боловсруулаагүйгээс тендерт оролцогч орж ирээгүй, цахим дэлгүүрт шаардлагатай материал байхгүй гэх шалтгаанаар 69,865.0 мянган төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалыг шууд гэрээ байгуулан худалдан авсан;
- Тус сургуульд 2021 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжүүлсэн Азийн хөгжлийн банкны "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл"-ийн хөрөнгө оруулалтаар "Интер сайнс" ХХК-иас нийлүүлэгдсэн, анх хүлээн авахад үйлдлийн систем гэмтэлтэйн улмаас ашиглах боломжгүй байсан 128,091.0 мянган

төгрөгийн 3 нэр төрлийн симулятор нэршилтэй сургалтын зориулалттай төхөөрөмжийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгасан;

- Тухайн байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 22,929.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй цэгэн гагнуурын аппарат нь зөвхөн үйлдвэрлэлийн зориулалттай тул сургалтад ашиглагдахгүй байгаа, тухайн хөрөнгөнд элэгдлийн зардал тооцон бүртгэж, үйл ажиллагааны үр дүнг буруу илэрхийлсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.9, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 41 дүгээр зүйлийн 41.1.1, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус коллеж нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх комиссын 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 2025/13 дугаар тогтоолоор 5 жилийн хугацаатайгаар магадлан итгэмжлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус сургууль нь олон улсын төслийн хүрээнд цахилгаан хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын техникч мэргэжлээр 29 хүн, уурхайн машин механизмын ашиглалтын техникч мэргэжлээр 23 хүн, шинээр байгуулсан сэргээгдэх эрчим хүчний сургалт, дадлагын танхимын анхны элсэгчдийн сургалтыг тус тус амжилттай зохион байгуулж, "Орон нутгийн дэмжлэгийн төсөл"-өөр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй орчныг бүрдүүлэх, жендерийн мэдрэмжтэй орчин, бодлого төлөвлөлтийг хийх, ногоон эко сургууль болох зорилтод чиглэсэн 12 төрлийн ажлыг хэрэгжүүлсэн байна.

Бусад асуудал

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 56 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.5 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна. Тус коллеж нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	825,410,392.44	1,073,214,407.77
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	188,737,392.74	232,535,029.85
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	188,737,392.74	232,535,029.85
31210	Төгрөг	188,737,392.74	232,535,029.85
31211	Төрийн сангийн харилцах	188,737,392.74	232,535,029.85
33	АВЛАГА	1,832,000.00	2,395,789.75
33500	Бусад авлага	1,832,000.00	2,395,789.75
33510	Байгууллагаас авах авлага	-	2,395,789.75
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,832,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	634,840,999.70	838,283,588.17
35400	Хангамжийн материал	634,840,999.70	838,283,588.17
35410	Бичиг хэргийн материал	23,473,671.00	14,203,614.00
35420	Аж ахуйн материал	92,364,065.50	101,261,050.90
35440	Түлш, шатах тослох материал	1,090,000.00	3,997,000.00
35460	Хүнсний материал	4,155,404.00	25,896,350.00
35470	Бусад хангамжийн материал	513,757,859.20	692,925,573.27
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,472,016,867.30	9,816,898,584.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,472,016,867.30	9,816,898,584.03
39200	Биет хөрөнгө	9,780,528,900.56	9,125,766,817.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,129,825,962.68	10,129,825,962.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,830,295,966.75)	(2,175,171,000.67)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,292,500,000.00	1,306,064,864.58
39204	Хуримтлагдсан элэгдэл	(698,774,549.83)	(883,757,195.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,742,471,657.60	1,862,434,975.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,008,323,197.07)	(1,283,095,271.49)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	199,065,247.98	228,668,185.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	(91,715,626.05)	(107,645,575.11)
39217	Ном	45,775,372.00	48,441,872.00
39300	Биет бус хөрөнгө	691,487,966.74	691,131,766.78
39303	Бусад биет бус хөрөнгө	716,101,758.00	716,101,758.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(24,613,791.26)	(24,969,991.22)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	11,297,427,259.74	10,890,112,991.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	60,413,321.81
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	60,413,321.81
41300	Өглөг	-	60,413,321.81
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	60,413,321.81
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,297,427,259.74	10,829,699,669.99
51	Засгийн газрын хувь оролцоо	11,297,427,259.74	10,829,699,669.99
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,346,405,152.09	-
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	2,346,405,152.09	-
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	2,346,405,152.09
51200	Хуримтлагдсан үр дүн	1,093,029,693.94	625,302,104.19
51210	Өмнөх үеийн үр дүн	1,616,866,015.92	1,093,029,693.94

51220	Тайлант үеийн үр дүн	(523,836,321.98)	(467,727,589.75)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,857,992,413.71	7,857,992,413.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	11,297,427,259.74	10,890,112,991.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,347,703,800.00	5,556,936,628.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	149,700,000.00	5,556,936,628.61
120	Нийтлэг татварын бус орлого	149,700,000.00	571,614,928.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	136,260,000.00	233,702,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	136,260,000.00	82,022,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	151,680,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	13,440,000.00	171,820,869.14
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	166,091,459.47
122	Тусламжийн орлого	-	4,985,321,700.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	4,985,321,700.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	4,985,321,700.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	4,985,321,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,198,003,800.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,181,003,800.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,181,003,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,000,000.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,871,540,121.98	5,999,635,919.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,871,540,121.98	5,999,635,919.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,648,697,721.98	5,866,853,919.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,454,578,918.00	2,950,950,685.00
210101	Үндсэн цалин	1,442,768,292.00	1,686,562,159.00
210102	Нэмэгдэл	706,221,351.00	948,945,866.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	138,777,753.00	140,258,868.00
210104	Урамшуулал	166,811,522.00	173,183,792.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	2,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	301,129,261.18	361,076,810.25
210201	Тэтгэврийн даатгалын зардал	201,813,161.18	246,115,546.35
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	24,829,000.00	29,038,411.24
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	12,414,500.00	15,323,896.99

Налайх дүүрэг дэх политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	12,414,500.00	14,036,274.49
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	49,658,100.00	56,562,681.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	421,866,189.60	862,745,976.70
210301	Гэрэл, цахилгаан	42,418,479.60	53,532,624.90
210302	Түлш, халаалт	353,342,100.00	783,658,721.81
210303	Цэвэр, бохир ус	26,105,610.00	25,554,629.99
2104	Хангамж, бараа материалын зардал	7,332,720.00	-
210401	Бичиг хэрэг	3,137,950.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	860,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,334,770.00	-
2105	Нормативт зардал	101,586,247.50	135,033,629.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,540.00	-
210502	Хоол, хүнс	101,525,707.50	135,033,629.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,429,150.00	56,052,450.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,637,780.00	12,703,250.00
210604	Урсгал засвар	80,791,370.00	43,349,200.00
2107	Томилолт, зочны зардал	-	23,120,000.00
210702	Дотоод албан томилолт	-	23,120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,200,000.00	169,920,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,200,000.00	169,920,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,220,575,235.70	1,307,954,368.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	154,159,081.48	194,895,432.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	170,268,797.00	233,789,473.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	896,147,357.22	879,269,463.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	222,842,400.00	132,782,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	222,842,400.00	132,782,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,042,400.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	169,800,000.00	131,782,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	1,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(523,836,321.98)	(442,699,290.55)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	25,028,299.20
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	25,028,299.20
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-	(25,028,299.20)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(523,836,321.98)	(467,727,589.75)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,334,731,800.00	5,220,856,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	136,728,000.00	5,220,856,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	136,728,000.00	235,534,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	136,728,000.00	235,534,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	136,728,000.00	83,854,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	151,680,000.00
122	Тусламжийн орлого	-	4,985,321,700.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	4,985,321,700.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	4,985,321,700.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	4,985,321,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,198,003,800.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,181,003,800.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,181,003,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,000,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,050,603,707.26	5,099,700,052.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,050,603,707.26	5,099,700,052.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,827,761,307.26	4,966,918,052.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,454,578,918.00	2,950,950,685.00
210101	Үндсэн цалин	1,442,768,292.00	1,686,562,159.00
210102	Нэмэгдэл	706,221,351.00	948,945,866.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	138,777,753.00	140,258,868.00
210104	Урамшуулал	166,811,522.00	173,183,792.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	2,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	301,129,261.18	363,472,600.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	201,813,161.18	247,215,800.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	24,829,000.00	29,064,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	12,414,500.00	14,532,100.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	12,414,500.00	14,532,100.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	49,658,100.00	58,128,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	421,866,189.60	802,332,654.89
210301	Гэрэл, цахилгаан	42,418,479.60	53,532,624.90
210302	Түлш, халаалт	353,342,100.00	723,245,400.00
210303	Цэвэр, бохир ус	26,105,610.00	25,554,629.99

Налайх дүүрэг дэх политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	-	3,300,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,300,000.00
2105	Нормативт зардал	86,387,000.00	156,546,500.00
210502	Хоол, хүнс	86,387,000.00	156,546,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	96,052,900.00	69,656,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,439,200.00	-
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	29,652,680.00	21,572,400.00
210604	Урсгал засвар	64,961,020.00	48,084,450.00
2107	Томилолт, зочны зардал	-	23,120,000.00
210702	Дотоод албан томилолт	-	23,120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,200,000.00	175,420,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,200,000.00	175,420,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	418,547,038.48	422,118,763.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	210,859,809.48	204,331,583.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	207,687,229.00	217,787,180.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	222,842,400.00	132,782,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	222,842,400.00	132,782,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,042,400.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	169,800,000.00	131,782,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	1,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	284,128,092.74	121,156,247.11
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	95,390,700.00	77,358,610.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	95,390,700.00	77,358,610.00
2200	Дотоод эх үүсвэрээр	95,390,700.00	77,358,610.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	95,390,700.00	77,358,610.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(95,390,700.00)	(77,358,610.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	188,737,392.74	43,797,637.11
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	188,737,392.74
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	188,737,392.74	232,535,029.85

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,346,405,152.09	7,857,992,413.71	1,616,866,015.92	11,821,263,581.72
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,346,405,152.09	7,857,992,413.71	1,616,866,015.92	11,821,263,581.72
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(523,836,321.98)	(523,836,321.98)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,346,405,152.09	7,857,992,413.71	1,093,029,693.94	11,297,427,259.74
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,346,405,152.09	7,857,992,413.71	1,093,029,693.94	11,297,427,259.74
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(467,727,589.75)	(467,727,589.75)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,346,405,152.09	7,857,992,413.71	625,302,104.19	10,829,699,669.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,246,475,400.00	5,220,856,300.00	25,619,100.00	99.5
12	Татварын бус орлого	5,246,475,400.00	5,220,856,300.00	25,619,100.00	99.5
120	Нийтлэг татварын бус орлого	238,110,500.00	235,534,600.00	2,575,900.00	98.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	82,110,500.00	83,854,600.00	(1,744,100.00)	102.1
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	156,000,000.00	151,680,000.00	4,320,000.00	97.2
122	Тусламжийн орлого	5,008,364,900.00	4,985,321,700.00	23,043,200.00	99.5
122005	Төсвөөс санхүүжих	5,008,364,900.00	4,985,321,700.00	23,043,200.00	99.5
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,366,994,500.00	5,177,058,662.89	189,935,837.11	96.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,366,994,500.00	5,177,058,662.89	189,935,837.11	96.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,234,212,500.00	5,044,276,662.89	189,935,837.11	96.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,998,638,300.00	2,950,950,685.00	47,687,615.00	98.4
210101	Үндсэн цалин	1,918,680,700.00	1,686,562,159.00	232,118,541.00	87.9
210102	Нэмэгдэл	938,981,300.00	948,945,866.00	(9,964,566.00)	101.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	134,976,300.00	140,258,868.00	(5,282,568.00)	103.9
210104	Урамшуулал	-	173,183,792.00	(173,183,792.00)	
210105	Гэрээт ажлын хөлс	6,000,000.00	2,000,000.00	4,000,000.00	33.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	380,509,500.00	363,472,600.00	17,036,900.00	95.5
210201	Тэтгэврийн даатгал	258,787,300.00	247,215,800.00	11,571,500.00	95.5
210202	Тэтгэмжийн даатгал	30,445,500.00	29,064,200.00	1,381,300.00	95.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,192,800.00	14,532,100.00	660,700.00	95.7
210204	Ажилгүйдлийн даатгал	15,192,800.00	14,532,100.00	660,700.00	95.7
210205	Эрүүл мэндийн даатгал	60,891,100.00	58,128,400.00	2,762,700.00	95.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	911,805,300.00	802,332,654.89	109,472,645.11	88.0
210301	Гэрэл, цахилгаан	58,510,400.00	53,532,624.90	4,977,775.10	91.5
210302	Түлш, халаалт	810,177,600.00	723,245,400.00	86,932,200.00	89.3
210303	Цэвэр, бохир ус	43,117,300.00	25,554,629.99	17,562,670.01	59.3
2104	Хангамж, бараа материалын зардал	3,300,000.00	3,300,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,300,000.00	3,300,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	160,800,500.00	156,546,500.00	4,254,000.00	97.4

Налайх дүүрэг дэх политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	160,800,500.00	156,546,500.00	4,254,000.00	97.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	134,647,400.00	134,582,490.00	64,910.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,125,000.00	31,084,600.00	40,400.00	99.9
210602	Тавилга	33,850,000.00	33,841,040.00	8,960.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	21,572,400.00	21,572,400.00	-	100.0
210604	Урсгал засвар	48,100,000.00	48,084,450.00	15,550.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	23,150,000.00	23,120,000.00	30,000.00	99.9
210702	Дотоод албан томилолт	23,150,000.00	23,120,000.00	30,000.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	176,745,900.00	175,420,000.00	1,325,900.00	99.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	176,745,900.00	175,420,000.00	1,325,900.00	99.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,615,600.00	434,551,733.00	10,063,867.00	97.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	226,666,600.00	216,764,553.00	9,902,047.00	95.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	217,949,000.00	217,787,180.00	161,820.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	132,782,000.00	132,782,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	132,782,000.00	132,782,000.00	-	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	131,782,000.00	131,782,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	188,737,392.74		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	188,737,392.74	232,535,029.85		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	91	89	2	97.8
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	48	46	2	95.8
620003	Үйлчлэх ажилтан	42	42	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Налайх дүүрэг дэх Политехник коллеж нь эрхэм зорилгоо “Геологи, уул уурхай, эрчим хүч, авто зам гүүрний барилгын чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдөх мэдлэг, ур чадварын уурхай байхад оршино” гэж тодорхойлсон байна.

Дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Удирдлага, засаглал, зохион байгуулалтыг оновчтой болгож, орчин үеийн менежментийн хандлагыг нэвтрүүлэх;
- Үнэлгээ, гэрчилгээжүүлэх, сургалт, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;
- Нийгмийн түншлэлийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлж, тогтвортой байдлыг хангах;
- Техник, технологийн хөгжлийн бодлого хэрэгжүүлж бүтээмжийг нэмэгдүүлэх;
- Санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах, хөрөнгө оруулалтын менежментийг хэрэгжүүлэх замаар сургуулийн өрсөлдөх чадвар, санхүүгийн чадавхыг дээшлүүлэх;
- Нийгмийн хариуцлагыг цогц байдлаар хэрэгжүүлж нийгэм хамт олонд үзүүлэх оролцоог нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус коллеж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд тайлант хугацаанд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" шинэчлэн батлагдсан;
- Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны 240 дүгээр "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг шинэчлэн батлах тухай тушаал;

- Сангийн сайдын 2025 оны 6 дугаар сарын 27-ны А/112 дугаар “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” тушаал;
- Сангийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 29-ний А/172 дугаар “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тушаал.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд Налайх дүүрэг дэх политехник коллежийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 12 зорилтын хүрээнд 56 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаснаас биелэлтийг хэрэгжилтийн дундаж хувь 99.5 байгаа тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Налайх дүүрэг дэх Политехник коллеж нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Налайх дүүрэг дэх Политехник коллеж нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 407,314.3 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	188,737.4	232,535.0	43,797.6
Авлага	1,832.0	2,395.8	563.8
Урьдчилгаа			
Бараа материал	634,841.0	838,283.6	203,442.6
Үндсэн хөрөнгө	10,472,016.9	9,816,898.6	(655,118.1)

Нийт хөрөнгө	11,297,427.3	10,890,113.0	(407,314.3)
Өр төлбөр		60,413.3	60,413.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	11,297,427.3	10,829,699.7	(467,727.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,297,427.3	10,890,113.0	(407,314.3)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 43,797.6 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг боловсролын сургалтын байгууллага дараагийн төсвийн жил дамжуулан зарцуулах зарчмын дагуу төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 232,535.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй .
- Тайлант хугацаанд 2,395.8 мянган төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүсгэсэн.
- Бараа материалын дансны үлдэгдэл 203,442.6 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал 179,167.8 мянган төгрөг, дотуур байрны хүнсний материал 21,740.9 мянган төгрөг, аж ахуйн материал 8,896.9 мянган төгрөгөөр тус тус өсч, бичиг хэргийн материал 9,270.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 655,118.1 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 393 дугаар тогтоолоор 83,381.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил акталж данснаас хассан болон тайланд хугацааны 879,269.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан.
- Өр төлбөрийн данс 60,413.3 мянган төгрөгөөр өссөн нь түлш халаалтын санхүүжилт дутуу олгогдсоноос шалтгаалсан.
- Засгийн хувь оролцоо дансны үлдэгдэл 467,727.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүн нөлөөлсөн.

Тус коллежийн программ хангамжийн дансанд бүртгэлтэй 2011, 2015, 2018 онуудад худалдан авч, ашиглаж байгаа 1,056.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программ, 18,690.6 мянган хөргөлтийн системийн туршилтын программ, 251.0 мянган төгрөгийн өртөгтэй вирусийн эсрэг программ хангамжууд байна. Тайлант онд программ хангамж хөгжүүлэхтэй холбоотой зардал гараагүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,301,357.4 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогоос 240,554.6 мянган төгрөг нийт зарлагыг 4,541,912.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 308,089.0 мянган төгрөгөөр түлш халаалтын зардлыг бууруулж, 4,233,823.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн орлогын бүрдэлтээс шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсөвт 3 удаа тодотгол хийгдэж Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/285 дугаар тушаалаар 1,012,652.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,008,364.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 82,110.5 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос 156,000.0 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр нийт 5,246,475.4 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 188,737.4 мянган төгрөг, гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,985,321.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 83,854.6 мянган төгрөг, туслах үйл ажилаагааны орлого 151,680.0 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны мөнгөн орлого 5,220,856.3 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж 5,177,058.6 мянган төгрөгийг зарцуулж, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 232,535.0 мянган төгрөг буюу гүйцэтгэл нь 96.6 хувьтай байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,177,058.6 мянган төгрөг буюу 88.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 47,687.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 109,472.6 мянган төгрөг, хоол хүнсний зардал 4,254.0 мянган төгрөг,бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 1,325.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 10,063.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
	71804-Тусгай мэргэжлийн боловсрол	5,366,994.5	5,177,058.6	189,935.9	96.5
1	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	947,405.3	837,918.0	109,487.3	88.4
2	80219-Харуул хамгаалалтын зардал	63,528.0	63,500.0	28.0	100.0
3	81806-Дотуур байрны үйлчилгээ	160,800.5	156,546.5	4,254.0	97.4
4	80802-Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллсаны тэтгэмж	131,782.0	131,782.0	-	100.0
5	81834-Боловсролын стандарт сургалт	3,521,059.7	3,495,093.6	25,966.1	99.3
6	83601-Нэмэлт олон улсын байгууллагаас олгосон	156,000.0	139,273.0	16,727.0	89.3
7	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	264,207.5	241,164.3	23,043.2	91.3
8	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт	122,211.5	111,781.2	10,430.3	91.5

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ.

1. Тайлант онд 93 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 89 орон тоогоор ажилласан байна. Тус коллеж нь тайлант онд 2 багш нярайн асрах чөлөөтэй, 1 багш жирэмсний амралттай, 1 үйлчлэгч тэтгэвэрт гарч нэмж ажилтан ажиллуулаагүй байна.
2. Захирлын 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн А/65 дугаар тушаалаар хоолны зардлыг 8.0 мянган төгрөгөөр тогтоож, тайланд онд 140,258.9 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон.
3. Сургалтын зардалд 11,550.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 5 төрлийн сургалтанд 10,210.0 мянган төгрөгийг зарцуулсан.
4. "Дүүрэн үйлс эмэгтэйчүүд хөгжлийн төв" төрийн бус байгууллагатай гэрээгээр 1,000.0 мянган төгрөгийн сургалт сурталчилгааны зардал гарсан байна.
5. Гадаад томилолтоор ажиллаагүй, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд дотуур байрны хүүхдийн хүнсний материалыг 164,581.0 мянган төгрөгөөр тендер шалгаруулалтын онцгой журмаар, 166,140.9 мянган төгрөгийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулахаар төлөвлөж, нийт 330,721.9 мянган төгрөгөөр баталжээ.

Дотуур байрны хүүхдийн хоолны 73,046.1 мянган төгрөгийн материалыг шууд худалдан авч худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Налайх дүүрэг дэх Политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Налайх дүүрэг дэх Политехник коллеж, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Пийк ОМ Аудит ХХК-ийн ахлах аудитор А.Мөнхцэцэг, аудитор А.Батболд нар гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Батчимэг, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Налайх дүүрэг дэх Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 4,871,540.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 48,715.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон болон хязгаарласан арга хэмжээг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 171 мэдээллээс 474,107.8 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.2 "Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим системд байршуулах мэдээллийг үнэн зөв, иж бүрэн, цаг хугацаанд нь мэдээлж байх, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, орлого, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар илэрсэн 128,182.9 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 3,968.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 9,932.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 3,886.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	3,968.1	2	3,968.1	100.0
Албан шаардлага	1	9,932.8	1	9,932.8	100.0
Зөвлөмж	4	3,886.2	4	3,886.2	100.0
Нийт дүн	7	17,787.1	7	17,787.1	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв, тодруулгуудын хамт бэлтгэж байгаа эсэхийг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 383,713.9 мянган төгрөгийн 7 зөрчил¹ илэрсэнд, 332,728.2 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 50,985.7 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 383,713.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 48,715.4 мянган төгрөгөөс давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

1.Илрүүлэлт: Тус коллеж нь дотуур байрны хүүхдийн хоолны 73,046.1 мянган төгрөгийн материалыг шууд худалдан авч худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 "Захиалагч дараах үндэслэлээр аж ахуй эрхлэгчдийн дунд хэлэлцээ хийх замаар гэрээ шууд байгуулж болно: 35.1.1. Захиалагч урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй", 41 дүгээр зүйлийн 41.1 "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна: 41.1.1. Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар бүлгийн 2.2 "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан боловсруулаагүй, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2.Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан тооцож, боловсруулаагүйгээс тендерт оролцогч орж ирээгүй, цахим дэлгүүрт шаардлагатай материал байхгүй гэх шалтгаанаар 69,865.0 мянган төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалыг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 "Захиалагч дараах үндэслэлээр аж ахуй эрхлэгчдийн дунд хэлэлцээ хийх замаар гэрээ шууд байгуулж болно: 35.1.1. Захиалагч урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй", 41 дүгээр зүйлийн 41.1 "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна: 41.1.1. Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар бүлгийн 2.2 "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, заавар, журмын дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.Илрүүлэлт: Тус сургуульд 2021 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжүүлсэн Азийн хөгжлийн банкны "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл"-ийн хөрөнгө оруулалтаар "Интер сайнс" ХХК-иас нийлүүлэгдсэн, анх хүлээн авахад үйлдлийн систем гэмтэлтэйн улмаас ашиглах боломжгүй байсан 3 нэр төрлийн симулятор нэршилтэй сургалтын зориулалттай төхөөрөмжийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч 128,091.0 мянган төгрөгөөр бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 16 дугаар зүйлийн 16.5.2 "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6 "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийг солиулах, засуулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тухайн байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 22,929.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй цэгэн гагнуурын аппарат нь зөвхөн үйлдвэрлэлийн зориулалттай тул сургалтад ашиглагдахгүй байна. Мөн сургалтад ашиглагдахгүй байгаа тухайн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцож үйл ажиллагааны үр дүнг буруу илэрхийлж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2 “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.6 “Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ашиглагдахгүй байгаа хөрөнгөнд элэгдэл тооцож, байгууллагын үр дүнг буруу илэрхийлж байгаа зөрчлийг арилгах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, хэрэгцээт газарт нь шилжүүлэх хүсэлт холбогдох газарт уламжлах

2. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын тооцоогоор 2,395.8 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 5 дугаар зүйлийн 5.1.5 “Хариуцлагатай байх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагаа барагдуулах, татвар, нийгмийн даатгалын тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд тайлагнаж, авлага үүсгэхгүй ажиллах

3. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Аудитын багийн түүвэрлэн хийсэн хяналтын тооллогоор 12 нэр төрлийн 492 ширхэг 631.8 мянган төгрөгийн бичиг хэргийн материал бараа материалын үлдэгдлээс зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ, 20 дугаар зүйлийн 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйл заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, эд хөрөнгийн тооллогын комиссын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх.

4. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус коллежийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, 37 нэр төрлийн 25,028.3 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасах хүсэлтийг ТӨБЗГ-т хүргүүлэхдээ үлдэх өртөггүй мэт жагсаалтыг буруу бэлтгэж шийдвэрлүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхийн төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйл заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.9 "Ерөнхий нягтлан бодогч нь аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах үүрэгтэй" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ТӨБЗГ-т мэдээ, тайлан, хүсэлтийг үнэн зөв хүргүүлж байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
1	Тус коллеж нь дотуур байрны хоолны материал худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.	1	73,046.1			1	73,046.1						
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан тооцож, боловсруулаагүйгээс тендэрт оролцогч орж ирээгүй, цахим дэлгүүрт шаардлагатай материал байхгүй гэх шалтгаанаар шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.	1	69,865.0			1	69,865.0						
3	Тус сургууль нь ашиглах боломжгүй 3 нэр төрлийн симулятор нэршилтэй сургалтын зориулалттай төхөөрөмжийг солиулах, засуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	128,091.0			1	128,091.0						
4	Тухайн байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй боловч, ашиглагдахгүй байгаа цэгэн гагнуурын аппаратын элэгдлийн зардлыг тооцон бүртгэсээр байгаа	1	22,929.8					1	22,929.8				
5	Нийгмийн даатгалын тооцоогоор 2,395.8 мянган төгрөгийн авлага үүсгэсэн	1	2,395.8					1	2,395.8				
6	Аудитын багийн түүвэрлэн хийсэн хяналтын тооллогоор 12 нэр төрлийн 492 ширхэг 631.8 мянган төгрөгийн бичиг хэргийн материал бараа материалын үлдэгдлээс зөрүүтэй байгаа	1	631.8					1	631.8				

Налайх дүүрэг дэх политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

7	Тус коллеж нь ТӨБЗГ-т анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгүүдийг данснаас хасах хүсэлтийг хүргүүлэхдээ үлдэх өртөггүй мэт жагсаалтыг буруу бэлтгэж шийдвэрлүүлсэн	1	25,028.3					1	25,028.3				
Дүн		7	383,713.9	-	-	3	332,728.2	4	50,985.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 171 мэдээллээс 474,107.8 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-			1	-
Дүн		1	-	-	-	1	-
Нийт дүн		1	-	-	-	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 305/АД150458

Улаанбаатар хот

САГ - 2026/152/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Налайх дүүрэг дэх политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургуульд 2021 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжүүлсэн Азийн хөгжлийн банкны "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл"-ийн хөрөнгө оруулалтаар "Интер сайнс" ХХК-иас нийлүүлэгдсэн, анх хүлээн авахад үйлдлийн систем гэмтэлтэйн улмаас ашиглах боломжгүй байсан 3 нэр төрлийн симулятор нэршилтэй сургалтын зориулалттай төхөөрөмжийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч 128,091,000.00 /Нэг зуун хорин найман сая ерэн нэгэн мянган/ төгрөгөөр бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4 "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Азийн хөгжлийн банкны "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл"-өөс нийлүүлэгдсэн ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийг солиулах, засуулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налайх дүүрэг дэх политехник коллежийн захирал /С.Мөнхбат/, нягтлан бодогч /Д.Эрдэнэзул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 304/А0150458

Улаанбаатар хот

САГ - 2026/152/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Налайх дүүрэг дэх политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан тооцож, боловсруулаагүйгээс тендерт оролцогч орж ирээгүй, цахим дэлгүүрт шаардлагатай материал байхгүй гэх шалтгаанаар 69,865,000.00 /Жаран есөн сая найман зуун жаран таван мянган/ төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалыг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-т "Захиалагч дараах үндэслэлээр аж ахуй эрхлэгчдийн дунд хэлэлцээ хийх замаар гэрээ шууд байгуулж болно: 35.1.1. Захиалагч урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна: 41.1.1. Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар бүлгийн 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, заавар, журмын дагуу зохион байгуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налайх дүүрэг дэх политехник коллежийн захирал /С.Мөнхбат/, нягтлан бодогч /Д.Эрдэнэзул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-46.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 303/A0150458

Улаанбаатар хот

САГ-2026/152/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Налайх дүүрэг дэх политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус коллеж нь дотуур байрны хоолны 73,046,100.00 /Далан гурван сая дөчин зургаан мянга нэг зуун/ төгрөгийн материалыг шууд худалдан авч, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-т "Захиалагч дараах үндэслэлээр аж ахуй эрхлэгчдийн дунд хэлэлцээ хийх замаар гэрээ шууд байгуулж болно: 35.1.1. Захиалагч урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна: 41.1.1. Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар бүлгийн 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, заавар, журмын дагуу зохион байгуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налайх дүүрэг дэх политехник коллежийн захирал /С.Мөнхбат/, нягтлан бодогч /Д.Эрдэнэзул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-46.Docx